ТӨВ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2022/162/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Зуунмод 2022 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: gereltekhburtgelaudit02@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

**Агуулга**

**Товчилсон үгийн жагсаалт** 3
**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл** 5
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** 5
**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** 6
**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** 7
**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** 7
**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** 9
**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** 10
**3. Аудитын тайлан** 11
**3.1 Ерөнхий зүйл** 11
**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт** 11
**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал** 12
**3.4 Материаллаг байдал** 12
**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга** 12
**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** 13
**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг** 14
**3.8 Аудитын гол асуудал** 14
**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 15
**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** 15
**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** 15
**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал** 15
**4. Аудитын илрүүлэлт** 16
**4.1 Залруулсан алдаа** 16
**4.2 Албан шаардлага** 16
**4.3 Зөвлөмж** 16

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/153

танай ________________-ны № ____________________-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ч.БАЯРСАЙХАН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 оны/ALBAN BICHIG 19020485

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **48,435,115.23** | **421,836,280.25** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | **55,137,531.34** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | **55,137,531.34** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 34,968,829.80 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | 20,168,701.54 |
| **33** | **АВЛАГА** | **-** | **285,745,660.00** |
| **335** | **Бусад авлага** | **-** | **285,745,660.00** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 285,745,660.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **48,435,115.23** | **80,953,088.91** |
| **351** | **Түүхий эд материал** | **16,196,852.44** | **38,917,992.12** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 470,456.10 | - |
| 35130 | Эм боох материал | 15,726,396.34 | 38,917,992.12 |
| **354** | **Хангамжийн материал** | **32,238,262.79** | **42,035,096.79** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 500,500.00 | 2,179,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,845,939.00 | 4,103,529.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,799,500.00 | 6,550,364.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,624,930.00 | 6,734,810.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 22,467,393.79 | 22,467,393.79 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,382,750,647.55** | **1,376,378,466.84** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,382,750,647.55** | **1,376,378,466.84** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,375,376,647.55** | **1,369,004,466.84** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,281,283,584.00 | 1,281,283,584.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (103,209,000.94) | (195,781,675.66) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 59,650,000.00 | 105,920,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (40,301,999.96) | (49,229,333.30) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 186,096,051.09 | 247,521,328.24 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (97,793,475.85) | (104,268,387.85) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 137,163,863.68 | 146,151,674.94 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (47,512,374.47) | (62,730,723.53) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 138,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **7,374,000.00** | **7,374,000.00** |
| 39301 | Програм хангамж | 435,000.00 | 435,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,374,000.00 | 7,374,000.00 |
| 39304 | Хасагдуулга | (435,000.00) | (435,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,431,185,762.78** | **1,798,214,747.09** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **413** | **Өглөг** | - | - |
| 41310 | Хоолны өглөг | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,431,185,762.78** | **1,798,214,747.09** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,431,185,762.78 | 1,798,214,747.09 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 272,050,531.95 | 272,050,531.95 |
| 51102 | - хувийн | 272,050,531.95 | 272,050,531.95 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **887,952,842.10** | **1,254,981,826.41** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 887,952,842.10 | 887,952,842.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 367,028,984.31 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 271,182,388.73 | 271,182,388.73 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,431,185,762.78** | **1,798,214,747.09** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **664,380,972.12** | **2,024,431,703.08** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **21,517,909.12** | **612,433,008.08** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **21,517,909.12** | **612,433,008.08** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 21,517,909.12 | 612,433,008.08 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 21,517,909.12 | 612,433,008.08 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **132,864,063.00** | **847,091,795.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 509,999,000.00 | 564,906,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **11,231,303.00** | **205,611,265.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,231,303.00 | 205,586,265.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 25,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **63,086,100.00** | **63,850,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 63,086,100.00 | 63,850,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **58,546,660.00** | **577,630,530.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 58,546,660.00 | 577,630,530.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **764,191,564.13** | **1,657,402,718.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **764,191,564.13** | **1,657,402,718.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **757,914,148.62** | **1,435,185,656.55** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **417,827,300.02** | **448,588,080.20** |
| 210101 | Үндсэн цалин | 268,797,220.02 | 234,584,726.76 |
| 210102 | Нэмэгдэл | 107,288,647.00 | 149,990,553.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,741,000.00 | 6,954,000.00 |
| 210104 | Урамшуулал | 38,000,433.00 | 57,058,799.59 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **61,996,216.47** | **60,597,679.70** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,805,699.29 | 42,781,409.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,176,497.80 | 4,567,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 904,238.17 | 3,642,455.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 226,059.59 | 855,171.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,883,721.62 | 8,751,343.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **57,634,141.00** | **53,477,655.24** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,699,748.00 | 5,498,130.04 |
| 210302 | Түлш, халаалт | 49,487,807.00 | 47,451,742.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 446,586.00 | 527,783.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **30,015,407.00** | **42,912,364.30** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,515,400.00 | 4,430,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,106,610.00 | 31,883,474.30 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,472,967.00 | 2,486,030.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,920,430.00 | 3,912,060.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 200,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **38,304,988.89** | **216,163,371.52** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 28,719,208.89 | 182,752,451.52 |
| 210502 | Хоол, хүнс | 9,585,780.00 | 22,582,920.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 10,828,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,725,000.00** | **30,900,605.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 470,000.00 | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,825,000.00 | 4,491,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,430,000.00 | 26,409,205.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **512,700.00** | **311,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 512,700.00 | 311,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **669,860.00** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 420,000.00 | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 249,860.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **144,228,535.24** | **582,234,300.59** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,878,800.00 | 443,757,054.87 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 127,349,735.24 | 138,477,245.72 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,277,415.51** | **222,217,062.22** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **214,344,517.46** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 214,344,517.46 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | **7,872,544.76** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 7,872,544.76 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **6,277,415.51** | |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,277,415.51 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(99,810,592.01)** | **367,028,984.31** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **5,639,060.84** | |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 5,639,060.84 | |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (5,639,060.84) | |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(105,449,652.85)** | **367,028,984.31** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 272,050,531.95 | 363,823,252.68 | 16,337,117.76 | 652,210,902.39 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 272,050,531.95 | 363,823,252.68 | 16,337,117.76 | 652,210,902.39 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | | 961,530,227.15 | 961,530,227.15 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **272,050,531.95** | **271,182,388.73** | **887,952,842.10** | **1,431,185,762.78** |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **272,050,531.95** | **271,182,388.73** | **887,952,842.10** | **1,431,185,762.78** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **272,050,531.95** | **271,182,388.73** | **887,952,842.10** | 1,431,185,762.78 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | | 367,028,984.31 | 367,028,984.31 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **272,050,531.95** | **271,182,388.73** | **1,254,981,826.41** | **1,798,214,747.09** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **642,863,063.00** | **1,126,253,035.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **642,863,063.00** | **1,126,253,035.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **509,999,000.00** | **564,906,900.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 509,999,000.00 | 564,906,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **11,231,303.00** | **205,611,265.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,231,303.00 | 205,586,265.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 25,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **63,086,100.00** | **63,850,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 63,086,100.00 | 63,850,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **58,546,660.00** | **291,884,870.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 58,546,660.00 | 291,884,870.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **639,122,333.00** | **1,061,018,383.66** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **639,122,333.00** | **1,061,018,383.66** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **632,844,917.49** | **838,801,321.44** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **418,428,944.05** | **448,588,080.20** |
| 210101 | Үндсэн цалин | 284,677,316.62 | 234,584,726.76 |
| 210102 | Нэмэгдэл | 101,490,207.21 | 149,990,553.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 6,954,000.00 |
| 210104 | Урамшуулал | 32,261,420.22 | 57,058,799.59 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **57,653,572.44** | **60,597,679.70** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,805,699.29 | 42,761,357.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,176,497.80 | 4,567,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 904,238.17 | 3,642,455.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 226,059.59 | 875,223.72 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,541,077.59 | 8,751,343.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **57,634,411.00** | **53,477,655.24** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,699,748.00 | 5,498,130.04 |
| 210302 | Түлш, халаалт | 49,487,807.00 | 47,451,742.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 446,856.00 | 527,783.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **35,192,427.00** | **47,229,668.30** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,990,900.00 | 6,109,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,906,110.00 | 33,634,338.30 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,472,967.00 | 2,486,030.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,822,450.00 | 3,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 2,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **32,764,203.00** | **180,462,248.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22,342,503.00 | 142,755,548.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,421,700.00 | 26,878,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 10,828,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,710,000.00** | **30,830,755.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,580,000.00 | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,700,000.00 | 5,098,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,430,000.00 | 25,732,355.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **512,700.00** | **311,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 512,700.00 | 311,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,669,860.00** | **-** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,000,000.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 420,000.00 | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 249,860.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **15,278,800.00** | **17,303,635.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,278,800.00 | 17,303,635.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,277,415.51** | **222,217,062.22** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **214,344,517.46** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 214,344,517.46 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **150,500.00** | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 150,500.00 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **6,126,915.51** | **7,872,544.76** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,126,915.51 | 7,872,544.76 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **3,740,730.00** | **65,234,651.34** |

| | | | |
|---|---|---|---|
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | | **10,097,120.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **10,097,120.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **10,097,120.00** |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 138,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 9,959,120.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | - | **(10,097,120.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **3,740,730.00** | **55,137,531.34** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 55,137,531.34 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **687,413,300.00** | **654,109,052.03** | **33,304,247.97** | **95.16** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **687,413,300.00** | **654,109,052.03** | **33,304,247.97** | **95.16** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **687,413,300.00** | **654,109,052.03** | **33,304,247.97** | **95.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **687,413,300.00** | **654,109,052.03** | **33,304,247.97** | **95.16** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **467,973,100.00** | **448,588,080.19** | **19,385,019.81** | **95.86** |
| 210101 | Үндсэн цалин | 292,935,700.00 | 234,584,726.75 | 58,350,973.25 | 80.08 |
| 210102 | Нэмэгдэл | 123,033,000.00 | 149,990,553.85 | (26,957,553.85) | 121.91 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,064,000.00 | 6,954,000.00 | 1,110,000.00 | 86.24 |
| 210104 | Урамшуулал | 43,940,400.00 | 57,058,799.59 | (13,118,399.59) | **129.85** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **63,176,300.00** | **60,597,679.70** | **2,578,620.30** | **95.92** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,457,300.00 | 42,761,357.30 | 1,695,942.70 | 96.19 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,679,700.00 | 4,567,300.00 | 112,400.00 | 97.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,743,800.00 | 3,642,455.22 | 101,344.78 | 97.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 936,000.00 | 875,223.72 | 60,776.28 | 93.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,359,500.00 | 8,751,343.46 | 608,156.54 | 93.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **61,350,000.00** | **52,644,011.84** | **8,705,988.16** | **85.81** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,600,000.00 | 4,664,486.64 | 7,935,513.36 | 37.02 |
| 210302 | Түлш, халаалт | 48,000,000.00 | 47,451,742.00 | 548,258.00 | 98.86 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 750,000.00 | 527,783.20 | 222,216.80 | 70.37 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **33,370,000.00** | **33,316,196.30** | **53,803.70** | **99.84** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,000,000.00 | 2,990,900.00 | 9,100.00 | 99.70 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,870,000.00 | 24,839,266.30 | 30,733.70 | 99.88 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,500,000.00 | 2,486,030.00 | 13,970.00 | 99.44 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **34,443,900.00** | **34,366,104.00** | **77,796.00** | **99.77** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 23,943,900.00 | 23,938,654.00 | **5,246.00** | **99.98** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 10,500,000.00 | 10,427,450.00 | **72,550.00** | **99.31** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,100,000.00** | **11,093,000.00** | **7,000.00** | **99.94** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,500,000.00 | 3,494,800.00 | **5,200.00** | 99.85 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 5,100,000.00 | 5,098,400.00 | **1,600.00** | **99.97** |
| 210604 | Урсгал засвар | 2,500,000.00 | 2,499,800.00 | **200.00** | 99.99 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,500,000.00** | **14,000.00** | **2,486,000.00** | **0.56** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,500,000.00 | 14,000.00 | **2,486,000.00** | 0.56 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,500,000.00** | **13,489,980.00** | **10,020.00** | 99.93 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,500,000.00 | 13,489,980.00 | **10,020.00** | 99.93 |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **687,413,300.00** | **697,784,070.00** | **(10,370,770.00)** | 101.51 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **564,906,900.00** | **564,906,900.00** | **-** | **100.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 564,906,900.00 | 564,906,900.00 | **-** | **100.00** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **63,850,000.00** | **63,850,000.00** | **-** | **100.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 63,850,000.00 | 63,850,000.00 | **-** | **100.00** |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **58,656,400.00** | **69,027,170.00** | **(10,370,770.00)** | **117.68** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 58,656,400.00 | 69,027,170.00 | **(10,370,770.00)** | **117.68** |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - | **-** | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 34,968,829.80 | **(34,968,829.80)** | **-** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | - | - | **-** | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | - | - | **-** | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **27.00** | **27.00** | **-** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | **-** | **100.00** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 22.00 | 22.00 | **-** | **100.00** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 | **-** | **100.00** |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | - | - | | |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО** | - | - | | |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны Гүйцэтгэл |
|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **402,864,263.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **402,864,263.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **188,519,746.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **13,913,472.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,118,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,795,072.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **147,262,464.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 119,983,214.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,451,250.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,828,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **23,232,555.00** |
| 210604 | Урсгал засвар | 23,232,555.00 |

| | | |
|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **297,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 297,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,813,655.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,813,655.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **214,344,517.46** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **214,344,517.46** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 214,344,517.46 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,436,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **5,436,000.00** |
| 222001 | Тоног төхөөрөмж | 5,436,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **428,468,965.00** |
| | **НД-ын САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **222,857,700.00** |
| | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 222,857,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **205,611,265.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 205,586,265.00 |
| | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 25,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 20,168,701.54 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Гэрэлтэх бүртгэл Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 15,283.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,462.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | - | 55,137.5 | 55,137.5 |
| **Авлага** | - | 285,745.6 | 285,745.6 |
| **Урьдчилгаа** | - | - | - |
| **Бараа материал** | 48,435.1 | 80,953.1 | 32,518.0 |
| **Үндсэн хөрөнгө** | 1,382,750.6 | 1,375,832.4 | 6,918.2 |
| **Нийт хөрөнгө** | **1,431,185.8** | **1,797,668.8** | **366,483.0** |
| **Өр төлбөр** | - | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | 272,050.5 | 272,050.5 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,431,185.8** | **1,797,668.8** | **366,483.0** |

Авлага дансны үлдэгдэл 285,745.6 мянган төгрөг болж нэмэгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас санхүүжигдэх Ковид 19-тэй холбоотой эмчилгээ үйлчилгээний зардлыг авлагаар тусгаснаас шалтгаалжээ. Эрүүл мэндийн даатгалаас авах 285,745.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 80,953.1 мянган төгрөг болж, 32,518.0 мянган төгрөгөөр өссөн Ковид 19 цар тахалтай холбоотой хандиваар ирсэн хөрөнгүүд нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Үүнд:

Эрүүл мэндийн газраас 443,852.8 мянган төгрөгийн вакцин, эмнэлгийн хэрэгсэл, эм бэлдмэл, оношлуур, хамгаалах хувцас, Заамар сумын Засаг даргын тамгын газраас 9,727.0 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, Заамар сумын “Заамар нутгийн хөгжлийг дэмжих сан”-аас 32,610.0 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, Төв аймгийн Онцгой байдлын газраас 1,235.2 мянган төгрөгийн хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгагч бодис, Нигүүн арвижих ХХК-аас 1,000.0 мянган төгрөгийн эмнэлгийн хувцас, Мед буян ХХК-аас 1,165.2 мянган төгрөгөөр эмнэлгийн хэрэгсэл, Монгол эм иимпекс ХХК-аас 834.8 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, нийт 490,425.0 мянган төгрөгийн хөрөнгө тус тус хандивласан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,376,378.4 мянган төгрөг болж, 6,372.2 мянган төгрөгөөр хасагдсан байна. Үндсэн хөрөнгийн данс Ковид 19 цар тахалтай холбоотой хандиваар ирсэн хөрөнгүүдээр нэмэгдсэн байна. Үүнд:

Заамар сумын “Заамар нутгийн хөгжлийг дэмжих сан”-аас 3,500.2 мянган төгрөгийн 2 ширхэг нөөтбүүк, 49,000.0 мянган төгрөгийн Hilux автомашин, Засаг даргын Тамгын газраас 1,500.00 мянган төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч, Иргэн Эрдэнэчимэгээс 380.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 850.0 мянган төгрөгийн 10 ширхэг фульс оксометр, Эрүүл мэндийн газраас 3,116.0 мянган төгрөгийн шүдний тоног төхөөрөмж, 5,896.6 мянган төгрөгийн 3 ширхэг суурин компьютер, 4,789.3 мянган төгрөгийн мөсөн ханатай хөргөгч, 340.2 мянган төгрөгийн хүйтэн сав, 2,635.4 мянган төгрөгийн 2 ширхэг хүчилтөрөгч өтгөрүүлэгч, нийт 122,007.7 мянган төгрөгийн хөрөнгө хандивласан байна.

Үндсэн хөрөнгийн данс акталж устгасан 3 нэр төрлийн 15,283.9 мянган төгрөгөөр, тайлант хугацааны элэгдлийн зардлын дүнгээр буурчээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлого өмнөх оноос 1,360,050.7 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь 443,852.8 мянган төгрөгийн бараа материал, 122,007.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал өмнөх оноос 893,211.2 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нормативт зардал, бусад бараа үйлчилгээний зардал байна. Энэ нь Ковид 19 тэй холбоотой эм бэлдмэл, нэг хэрэглэдэг хамгаалалтын хувцасны зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 683,799.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 683,799.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,613.6 мянган төгрөгөөр нэмж, 687,413.3 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 687,413.3 мянган төгрөгийн төсөв батлснаас 564,906.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 63,850.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 69,027.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 697,784.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, улсын төсвөөс 564,906.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 63,850.0 мянган төгрөгийн, эрүүл мэндийн сангаас 69,027.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 654,109.1 мянган төгрөгийг зарцуулж, 7,872.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлтээр нийт 428,468.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал зардалд 402,864.2 мянган төгрөгийг, хөрөнгийн зардалд 5,436.0 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 20,168.7 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас Ковид-19 өөр хэвтэн эмчлүүлсэн, гэрийн тусгаарлалтад хамрагдсан, дархлаажуулалтад хамрагдсан өвчтөнүүдээс эмчилгээ үйлчилгээний төлбөрийн 424,754.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлтээр Ковид 19-тэй холбоотой түргэвчилсэн оношилгоо шинжилгээний төлбөр 25.0 мянган төгрөг, саагийн вакцинжуулалтын томилолтод 173.6 мянган төгрөг, сүрьеэгийн тандалт судалгааны багийн шатахууны зардал 267.6 мянган төгрөг, цар тахлын үеийн тандалт судалгааны багийн урамшууллын зардал 1,008.0 мянган төгрөг, сорьц тээвэрлэх зардал 440.0 мянган төгрөг, Монгол бичигтэн байгууллагаар шалгарсны 300.0 мянган төгрөг, Төв аймгийн Засаг даргын тамгын газраас шатахууны 500.0 мянган төгрөг, Сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос эрт илрүүлэг болон сорьц тээвэрлэлтийн үзлэгт шалгарсны шагнал 1,000.0 мянган төгрөгөөр, нийт 3,714.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан авсан орлого өмнөх оноос 590,915.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, энэ нь Ковид 19 цар тахалтай холбоотой 490,425.0 мянган төгрөгийн бараа материал, 122,007.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар хүлээн авснаас шалтгаалжээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 2,060,688.6 мянган төгрөгийн 134 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,732,381.9 мянган төгрөгийн 47 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,540.7 мянган төгрөгийн 4 алдаа зөрчлийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - | - | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 4 | 1,540.7 | 4 | 1,540.7 | - | - | 100 |
| **Нийт дүн** | **4** | **1,540.7** | **4** | **1,540.7** | **-** | **-** | **100** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,232,385.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 490,425.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 9,578.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,732,381.9 мянган төгрөгийн шилэн данстай холбоотой зөвлөмж болон үндсэн хөрөнгийн данстай холбоотой зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Бараа материалын дансанд хандив тусламжаар хүлээн авсан 490,425.1 мянган төгрөгийн хөрөнгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, илэрхийлэн бүртгэж, тайлагнах", санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын дансанд хандив тусламжаар хүлээн авсан 490,425.1 мянган төгрөгийн хөрөнгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж залруулав.

### 4.2 Албан шаардлага

Байгууллага нь нийт 7 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 9,578.7 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, ”иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “*албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*”, 4.2.1.8-д “*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 168 ширхэг 83,114.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр

тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", санхүүгийн тайлангийн аудитын "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. *Өгсөн зөвлөмж:*

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## *2. Шилэн данстай холбоотой асуудал*

*2.1. Илрүүлэлт:*

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 2,060,688.6 мянган төгрөгийн 134 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,732,381.9 мянган төгрөгийн 47 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. *Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал: | | | | | | | | | | | |
| 1 | Хандиваар ирсэн хөрөнгийг санхүүгийн үр дүнгийн тайлан; тайлагнаагүй | 1 | 490,425.1 | 1 | 490,425.1 | | | | | | |
| 2 | Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй | 1 | 9,578.7 | | | | | 1 | 9,578.7 | | |
| 3 | Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна | 1 | - | | | | | | | 1 | - |
| **Дүн** | | **3** | **500,003.8** | **1** | **490,425.1** | **-** | **-** | **1** | **9,578.7** | **1** | **-** |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал: | | | | | | | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй | 1 | 1,732,381.9 | | | | | | | 1 | 1,732,381.9 |
| **Дүн** | | **1** | **1,732,381.9** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **1,732,381.9** |
| **Нийт дүн** | | **4** | **2,232,385.7** | **1** | **490,425.1** | **-** | **-** | **1** | **9,578.7** | **2** | **1,732,381.9** |